




ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд хоёр долоо хоног дараалан буурлаа. Мэдээлэл технологи болон эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш унасан үзүүлэлттэй байна. Газрын тосны ханш сүүлийн нэг жилийн хамгийн доод түвшинд хүрэв. Энэ долоо хоногт ус, цахилгаан, дулаан хангамжийн компаниудын хувьцааны ханш хамгийн ихээр өсчээ.

FAANG компаниуд буюу "Facebook", "Amazon.com", "Apple", "Netflix" болон "Google" компаниудын хувьцааны ханш өөрийн дээд үнээс 20 гаруй хувиар унасан үзүүлэлттэй байна.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан даамжирав. Азийн эдийн засгийн чуулга уулзалт дээр хоёр улсын эрх баригчид тохиролцоонд хүрч чадаагүй учраас энэ сарын сүүлээр болох "Их-20" орнуудын чуулга уулзалт дээр ч мөн тохиролцоонд хүрч чадахгүй болов уу гэсэн хүлээлтийг үүсгэсэн байна.

"Goldman Sachs" компанийн шинжээчдийн үзэж байгаагаар 2019 оны сүүлчээр АНУ-ын эдийн засгийн өсөлт одоогийн 3.5%-аас удааширч 1.75%-д хүрэх ажээ. Энэ нь санхүүгийн нөхцөл байдал чангарч, төсөв хумигдахтай холбоотой юм. 2020 оны эхээр ажилгүйдлийн түвшин 3%-д хүрнэ хэмээн таамагласан байна. Хөдөлмөрийн хөлсний хэмжээ 3.25-3.5%-аар өсч, суурь инфляцийн түвшин 2019 оны эцэст 2.25% болох юм. Инфляцийн түвшинд ийм хэмжээнд байснаар Холбооны нөөцийн банк бодлогын хүүндээ өөрчлөлт оруулахгүй ажээ. Энэ оны 12-р сард Холбооны нөөцийн банк бодлогын хүүг өсгөнө гэсэн хүлээлттэй байгаа бол 2019 онд тус байгууллага бодлогын хүүг 4 удаа нэмнэ хэмээн шинжээчид таамаглажээ.

Европ: "Brexit" хэлэлцээр болон Итали улсын төсвийн асуудалтай холбоотойгоор Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд буурчээ.

Их Британийн Ерөнхий сайд хатагтай Тереза Мэйн Засгийн газрын боловсруулсан "Brexit" хэлэлцээрийн төслийг Европын Холбооны удирдагчид баталлаа. Харин одоо Их Британийн Парламент тус хэлэлцээрийг батлах шаардлагатай аж. Ингэснээр фунтын ханш ам.долларын эсрэг чангарчээ.

Италийн Засгийн газар Европын Холбооноос тавьсан шаардлагын дагуу 2019 оны төсвийн зардлаа танахаас татгалзсан хэвээр байв. Италийн эрх баригчид төсвийн зардлыг нэмснээр эдийн засгийн өсөлтийг дэмжиж, үүнийг дагаад татварын орлого нэмэгдэнэ хэмээн үзэж байгаа аж.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн гол үзүүлэлт болох Nikkei 225 индекс 0.16%-аар буурчээ.

Япон улсын Сангийн яамны мэдээлснээр 10-р сард тус улсын гадаад худалдааны тэнцэл 4 тэрбум ам.долларын алдагдалтай гарчээ. Энэ нь шинжээчдийн таамагласнаас 9 дахин их байгаа юм. Нийт импорт (газрын тос, байгалийн хий, үр тариа) 20 хувиар, экспорт (авто машин, хөдөлгүүр, хагас дамжуулагч) 8 хувиар тус тус өсчээ.

Япон улсын статистикийн байгууллагын мэдээлснээр 10-р сард тус улсын хэрэглээний үнийн суурь индекс 1.0%-аар өссөн байна. Инфляцийн түвшин Японы төв банкны зорилтот 2.0%-аас бага хэвээр байгаа юм. Газрын тосны ханш унаж байгаа нь инфляцийн түвшинг бууруулна хэмээн шинжээчид үзэж байна.

БНХАУ: АНУ-ын Засгийн газар мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс Хятадын "Huawei" компаниас харилцаа холбооны тоног төхөөрөмж худалдан авахгүй байхыг уриалж байгаа талаар мэдээлэл гарч, БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд буурсан үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,592.93	-2.81% ▼
Dow Jones	АНУ	24,285.95	-4.44% ▼
S&P 500	АНУ	2,632.56	-3.79% ▼
Nasdaq	АНУ	6,938.98	-4.26% ▼
S&P/TSX	Канад	15,010.73	-0.96% ▼
FTSE 100	Их Британи	6,952.86	-0.87% ▼
S&P/ASX 200	Австрали	5,716.20	-0.25% ▼
Nikkei 225	Япон	21,646.55	-0.16% ▼
Hang Seng	Хонг Конг	25,927.68	-0.98% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	106.47
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	94.55
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	93.56
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.03
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.63
DBM' 2023	USD	7.250%	97.76
TDBM' 2020	USD	9.375%	104.80

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.322	0.02 ▲
Libor 3M	2.691	0.05 ▲
Libor 6M	2.886	0.02 ▲
Libor 1YR	3.121	0.00 ▼
US 6M Bond	3.050	-0.01 ▼
US 2YR Bond	2.827	0.03 ▲
US 3YR Bond	2.850	0.01 ▲
US 5YR Bond	2.882	0.00 ▲
US 10YR Bond	2.528	0.03 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.11.23	Өөрчлөлт
USD	2,596.89	0.86% ▲
CNY	374.11	0.81% ▲
EUR	2,963.70	0.80% ▲
RUB	39.60	1.49% ▲
KRW	2.29	-0.43% ▼
JPY	23.01	0.83% ▲
CAD	1,967.49	0.45% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,223.05	0.12% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.29	-0.76% ▼
Зэс	USD/lb.	278.55	0.41% ▲
Нүүрс	USD/MT	97.02	-1.55% ▼
WTI газрын тос	USD/bbl.	50.42	-11.84% ▼
Brent газрын тос	USD/bbl.	58.8	-12.79% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	4.31	-7.11% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. X	6.30%
Бодлогын хүү	2018. X	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. IX	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. IX	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	17.50%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. IX	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 45 компанийн 587.1 сая төгрөгийн 1,779,972 ширхэг хувьцаа арилжигдав.


“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 32.07%-аар буюу хамгийн ихээр өсч 39,700 төгрөгт хүрч хаагдсан бол “Дөрвөн-Уул” /DRU/ компанийн хувьцаа 23.27%-аар буурч 1,500 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 1,471 ширхэг үнэт цаас 157.0 сая төгрөгөөр арилжаалагджээ.


11-р сарын 23-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,293.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,592.93 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.81%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	744.1
Зах зээлийн үнэлгээ	2,293,876.2

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,592.93	-2.81% ▼
MSE I индекс	9,264.31	-4.44% ▼
MSE II индекс	8,284.32	-2.39% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	280,444	161,228,479
Эрдэнэ Ресурс	252,871	152,882,636
Девелопмент Корп.		
ЛэндМН ББСБ	851,083	59,642,830
Таван толгой	8,115	54,095,300
Говь	1,070	34,600,440

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	39,700.00	32.07% ▲
Хорин хоёрдугаар бааз	379.00	31.83% ▲
Хөвсгөл алтан дуулга	819.00	22.32% ▲
Хүрд	2,128.00	14.35% ▲
Э-транс ложистикс	97.98	9.41% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дөрвөн-Уул	1,500.00	-23.27% ▼
Монинжбар	110.00	-15.38% ▼
Тахь-ко	10,200.00	-15.00% ▼
Таван толгой	6,595.00	-14.35% ▼
Материалимпекс	7,700.00	-9.41% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	313,904,260
Би Ди Сек	257,281,651
Голомт Капитал	179,512,921
Ард капитал групп	94,401,756
Ти Ди Би Капитал	88,557,178

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	564.00	600,454
Таван толгой	6,595.00	347,327
Говь	32,600.00	254,317
МИК	10,900.00	225,732
Сүү	227.63	78,305

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	492	52,555,440	106,820	106,820	156	15.140%
2	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	312	33,327,840	106,820	106,820	156	15.140%
3	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	147	15,662,850	106,550	106,550	156	15.140%
4	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	520	55,406,000	106,550	106,550	156	15.140%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.10-нд олгов
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	2018.03.06	2018.09.21-нд олгов
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Цемент шохой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Цемент шохой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 11-р сарын 15-ны өдрийн 18/62 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12-р сарын 25-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.12.25-ны өдрийн 10:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.12.07-ны өдөр

Хуралдах газар: Сэлэнгэ аймаг, Сайхан сум, “Цемент шохой” ХК-ийн хурлын зааланд

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
2. Компанийн тухай хууль болон Компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг: Сэлэнгэ аймаг, Сайхан суманд байрлах “Цемент шохой” ХК-ийн байранд ирэх эсхүл харилцдаг брокерын компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Хурал зохион байгуулах коммис: 9914-4535, 9968-3422, 9473-6330

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Гурил тэжээл Булган” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Гурил тэжээл булган” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 11-р сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12-р сарын 25-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.12.25-ны өдрийн 11:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.12.05-ны өдөр

Хуралдах газар: ХУД, 15-р хороо Чингисийн өргөн чөлөө, “Бэрэн групп” ХХК-ийн хурлын зааланд

Хурлаар хэлэлцэх асуудал: “Гурил тэжээл булган” ХК-ийн өмчлөлийн 000097126 тоот гэрчилгээтэй, Улсын бүртгэлийн Y-0405000525 дугаарт бүртгэгдсэн, Булган аймгийн Булган сумын 5-р багт байршилтай үл хөдлөх хөрөнгийг иргэн Б. Сарангэрэл /РД: ЧВ64042201/-ийн өмчлөлд шилжүүлэх тухай

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг: Ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд ХУД-ийн 15-р хороо, “Бэрэн групп” ХХК-ийн байранд ирэх эсхүл харилцдаг брокерын компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Хурал зохион байгуулах коммис: 8803-5353

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Шарын гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 33 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.12.26-ны өдрийн 13:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.12.05-ны өдөр

Хуралдах газар: Улаанбаатар зочид буудлын хурлын зааланд

Хурлаар хэлэлцэх асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг: Ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд Дархан-Уул аймгийн Шарын гол суманд байрлах компанийн байранд ирэх эсхүл харилцдаг брокерын компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.


Хурал зохион байгуулах коммис: 8802-6677, 9929-3913

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Ган хийц” болон “Гермес центр” ХК-ууд ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Ган хийц” ХК-ийн 2017 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 90 төгрөг тараасныг 2018 оны 9-р сарын 21-ны өдөр, “Гермес центр” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 4 төгрөг 50 мөнгө тараасныг 2018 оны 10-р сарын 10-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв



МХБ-д бүртгэлтэй 200 гаруй хувьцаат компанийн 80 хувь нь “хангалтгүй” үнэлгээ авчээ

Бүртгэлтэй 200 гаруй компанийн 80 орчим хувийнх нь хууль, журам болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй эсвэл дутуу байна гэж Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ.

Монголын Хөрөнгийн бирж бүртгэлтэй компаниуддаа хагас жил тутам үүргийн хэрэгжилтийн судалгаа явуулдаг. Хамгийн сүүлийн буюу 2018 оны эхний хагас жилийн байдлаар энэхүү судалгаанд 201 компани хамрагдсанаас 46 нь хангалттай гэсэн үнэлгээ авчээ. Үүргийн хэрэгжилт хангалттай буюу 80 хувиас дээш гүйцэтгэлтэй компаниудаас онцолбол, “Говь”, “Э-Транс ложистикс”, “Айтүүлс” зэрэг I, II ангилалд бүртгэлтэй арилжааны идэвх өндөр компаниуд байна. Харин 100 хувь Төрийн өмчит 19 компанийг энэхүү судалгаанд хамруулаагүй аж.

Үүргийн хэрэгжилтийн судалгаа нийт 10 шалгууртайгаас оны эхний хагаст бүх шалгуурыг биелүүлсэн 11 компани байна. Харин 52 компани эдгээр 10 шалгуурын алийг нь ч биелүүлээгүй байгаа талаар Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ. Үүргээ огт биелүүлээгүй 52 компани нь Монголын Хөрөнгийн биржийн III ангилалд бүртгэлтэй компаниуд аж.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Тавантолгойн уурхайгаас нүүрс ачихыг түр хугацаагаар зогсоолоо

Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтэрч байгаа автомашины тоо огцом буурсантай холбоотойгоор Зам, Тээврийн хөгжлийн яам болон Авто тээврийн үндэсний төв уурхайн ачилтуудыг түр зогсоох шийдвэр гаргасан байна.

Улмаар хил, гаалийн байгууллагуудтай хамтарч нүүрсний тээвэр хэвийн болох хүртэл лац олгохгүй байхаар зохион байгуулсан талаар Авто тээврийн үндэсний төв мэдээллээ. БНХАУ-ын тал жолооч нарын мэдээллийг бүртгэлжүүлж ухаалаг систем нэвтрүүлж байгаа гэсэн шалтгаанаар татан авалтаа эрс бууруулаад байгаа юм. Үүнтэй холбоотойгоор жолооч нарын мэдээллийг урьдчилан явуулах байдлаар асуудлыг шийдэхээр БНХАУ-ын талтай тохиролцсон гэж Гашуунсухайт боомтын захиргаа мэдээллээ.

Гашуунсухайт-Ганцмод боомтоор даваа гарагт нүүрсний 99 автомашин, "Оюу Толгой"-ийн 27 автомашин нэвтэрч экспорт хийсэн байна. Нүүрсний экспортын тухайд ойролцоогоор 7,400 орчим тонн нүүрс гарсан гэсэн үг юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

АМГТГ: Шатахууны үнэ ирэх оны эхээр буурах магадлалтай

2019 оны I, II сараас шатахууны үнэ аажимдаа буурах магадлалтай талаар Ашигт малтмал газрын тосны газраас мэдээллээ.

Өнгөрсөн хугацаанд дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өссөн нь шатахууны үнэд нөлөөлсөн. Өсөлттэй холбоотойгоор ОХУ-ын "Роснефть" компани өнгөрсөн X сард шатахууны хилийн үнийг тонн тутамд 45-85 ам.доллараар нэмсэн. Гэхдээ 11-р сард ОХУ-аас нийлүүлсэн АИ-92 бензин 766-765 ам.доллар болж буурсан байна. 11-р сард импортлосон шатахуун XII дугаар сард борлуулалтад гардаг учраас дараагийн саруудад шатахууны үнэ буурах магадлалтай хэмээн мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

"Southgobi Resources" компанийн "CIC"-д төлөх 41.8 сая долларын төлбөр дефолтод оров

Овоот толгойд олборлолт хийж байгаа "Southgobi Resources" компани БНХАУ-ын "China Investment Corporation"-д 11-р сарын 19-нд багтаан төлөх ёстой 41.8 сая ам.долларын төлбөрөө хугацаандаа төлж барагдуулаагүй учраас төлбөр дефолтод оржээ.

Үүнд 33.8 сая ам.долларын бэлэн мөнгөний хүүний төлбөр болон холбогдох бусад зардал байгаагаас гадна найман сая ам.долларын дүйцүүлсэн хувьцааны төлбөр багтаж байгаа. "Southgobi Resources" болон "China Investment Corp" компаниуд төлбөрийн эргэн төлөх төлөвлөгөөн дээр тохиролцоонд хүрээгүй байгаа талаар "Southgobi Resources" мэдээлсэн. Энэхүү зээлийг хувьцаанд хөрвөх өрийн бичиг хэлбэрээр авсан ба талуудын хооронд 2017 онд байгуулсан гэрээний дагуу өрийн бичиг дефолтод ороод байна.

"Southgobi Resources" компанийн хувьд III улиралд 700 мянган тонн нүүрс борлуулж, 24.5 сая ам.долларын орлого олсон талаар санхүүгийн тайландаа дурджээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ХХААХҮЯ: 11-р сарын 7-ны өдрийн байдлаар мах, махан бүтээгдэхүүний экспорт 43.3 мянган тоннд хүрээд байна

2018 оны 11-р сарын 7-ны өдрийн байдлаар мах, махан бүтээгдэхүүн экспорт 43.3 мянган тоннд хүрээд байгаа талаар ХХААХҮЯ мэдээллээ.

Нийт 27 мянган тонн хонь, ямаа, үхэр, адууны мах, 16 мянган тонн дулааны аргаар боловсруулсан мах экспортолсон байна. Мөнгөн дүнгээр илэрхийлбэл 104 сая ам.доллар буюу 267.4 тэрбум төгрөгийн экспорт хийгээд байгаа юм. Энэ нь өмнөх онуудтай харьцуулахад экспортын мах, махан бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, дулааны аргаар боловсруулсан махны экспорт огцом өссөн үзүүлэлт гэдгийг ХХААХҮЯ онцоллоо. Монгол малын эрүүл ахуйг сайтар хангаснаар мах, махан бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх боломж их байгааг "Мөнхийн болор" компанийн Гүйцэтгэх захирал онцолж байсан юм.

Мөн "Дархан Мийт Фүүдс" компани энэ он гарсаар 13-14 мянган тонн мах экспортлоод байгаа талаар мэдээллээ. Нийт экспортын дийлэнхийг ОХУ, БНХАУ-д хийсэн байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



2018-2019 онд улаан буудай импортлохгүй

Ургац хураалтын урьдчилсан дүнгээр 428.6 мянган тонн улаан буудай, 267.1 мянган тонн төмс, хүнсний ногоо тус тус хураан авсан талаар ХХААХҮЯ мэдээллээ. Ингэснээр буудай, төмсний хэрэгцээг дотоодоос хангах боломжтой болжээ.

Шинэ ургацаас гурилын үйлдвэрүүдэд 226.4 мянган тонн, тариалан эрхлэлтийг дэмжих санд 50.5 мянган тонн буудайг нийлүүлсэн байна. Харин 63.1 мянган тонн буудай борлуулалтын шатандаа байгаа талаар салбарын яам мэдээлсэн юм. "Хөвсгөл алтан дуулга" компанийн хувьд энэ онд нийт 5.8 мянган тонн улаан буудай хурааж га-ийн дундаж ургац 15.1 центнер байсан талаар онцоллоо. Энэ нь сүүлийн зургаан жилийн дунджаас 36 хувиар өндөр үзүүлэлт болсон байна. Тус компани энэ жилийн улаан буудайн чанарыг "Сайн" гэж дүгнэлээ. Мөн шинэ ургацын буудайн гурилыг зах зээлд нийлүүлж эхэлсэн байна.

Үүнээс гадна 19.5 мянган өрхийн 8.7 сая толгой мал отроор өвөлжиж хаваржих зохион байгуулалт хийсэн талаар ХХААХҮЯ мэдээллээ. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг улсын хэмжээнд 89.1 хувьтай хангажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ



Засгийн газрыг огцруулах бичиг өргөн барьсны дараа “Гэрэгэ” бондын ханш буурав

Арилжаа эхэлснээс хойш Монгол Улсын Засгийн газрын бондуудын үнэ эргэн буурч тогтлоо. Тухайлбал, “Гэрэгэ” бондын үнэ хоёрдогч зах зээлд 0.12 хувиар буурсан байна.

Засгийн газрын гишүүн огцрох өргөдлөө өгсөн, 2019 оны Төсвийн тухай хуульд Ерөнхийлөгч хориг тавьсан зэрэг үйл явдлууд өрнөсөн 10-р сараас хойш Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээл дэх бондын хувьд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөж өсөөд байна. Тухайлбал, 2023 онд төлөх “Гэрэгэ” бондын хөрөнгө оруулагчдын шаардах өгөөж 6.753 дээр хэлбэлзэж байна. Энэ нь сүүлийн долоо хоногийн хамгийн дээд түвшин юм. Мөн 10-р сараас хойш долоо орчим хувь өссөн үзүүлэлт ажээ.

Харин 2023 онд төлөх “Мазаалай” бондын хөрөнгө оруулагчдын шаардах өгөөж 10-р сараас хойш 12 орчим хувиар өсч, 5.785 хувь дээр хэлбэлзэж байна.

Засгийн газрыг огцруулах бичигт 27 гишүүн гарын үсэг зурж, УИХ-д өргөн барьсан гэж УИХ-ын гишүүн Д.Хаянхярваа даваа гарагт мэдээллээ. Засгийн газрыг огцруулах бичиг өргөн барьсан шалтгаан нь Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас нэр бүхий гишүүд зээл авсан болон Засгийн газар Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаатай холбоотой гэж хэвлэлийн бага хурлын үеэр мэдэгдлээ. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Төрийн байгуулалтын байнгын хороо долоо хоногийн дотор, байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын нэгдсэн чуулганаар долоо хоногийн дотор хэлэлцүүлж шийднэ гэж заасан байна.

Энэ сард “S&P” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В” болгон дээшлүүлж, төлөвийг тогтвортой хэвээр хадгалсан билээ. Тус агентлагууд Монгол Улсын төсвийн зорилтууд давж биелсэн ч гадаад, дотоод “шок”-уудад мэдрэг хэвээр байгааг анхааруулсан. Эргэн санахад, олон улсын агентлагууд их хэмжээний төсвийн алдагдал болоод улс төрийн тогтворгүй байдалтай холбоотойгоор Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулж байсан удаатай юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

World Economics: Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс 5 сар дараалан буурлаа

11-р сард Монгол Улсын эдийн засгийн идэвхжил саарсантай холбоотойгоор борлуулалтын менежерүүдийн индекс огцом буурсан гэж “World Economics” байгууллага мэдээллээ.

2018 он гарснаас хойш зургаан сар дараалан өсөөд байсан энэхүү индекс сүүлийн таван сарын турш унахад бизнесийн итгэл буурсан нь голлон нөлөөлсөн гэж тус байгууллага үзэж байгаа юм. Мөн бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж байгаа нь энэхүү индекст сөргөөр нөлөөлсөн байна. Тухайлбал, шатахуун, цахилгаан, хүнсний үнэ огцом нэмэгдсэн нь Монгол Улсын эдийн засгийн идэвхжил саарахад нөлөөлсөн гэж “World Economics” дүгнэжээ. Харин БНХАУ нүүрсний импортоо хязгаарласан нь төдийлөн нөлөөлөөгүй гэдгийг тайландаа онцолсон байна.

“Монгол Улсын эдийн засгийн идэвхжил буурсан нь богино хугацааны өөрчлөлт. Харин урт хугацаагаар авч үзвэл эдийн засаг эрчимжиж, шинэ ажлын байр нэмэгдэж байгаа нь эерэг үзүүлэлт” гэдгийг тайландаа дурджээ. Өөрөөр хэлбэл сүүлийн таван сар дараалан унасан борлуулалтын менежерүүдийн индекс өсөлтийн бүсэд хадгалагдсаар байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Импортын өсөлт он гарснаас хойш 40 орчим хувьд хадгалагдлаа

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 10-р сард импорт өмнөх оны мөн үеэс 39 хувиар буюу 1.4 тэрбум ам.доллараар өссөн байна. Ингэснээр импорт он гарснаас хойш 40 орчим хувиар өссөн трендээ хадгаллаа.

Эдийн засгийн өсөлт эрчимжсэнээр хөрөнгө оруулалтын шинжтэй импорт эрчимтэй өсөж байгаа гэж Монголбанк мэдээлсэн юм. Импортын өсөлтийг харвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 19 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 7 нэгж хувийг, аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Хэдий тийм боловч дотоодын эрэлт нэмэгдэж байгаа нь урсгал дансны алдагдлыг ихэсгэж, нөөц хуримтлуулахад саад болж байна гэж Олон Улсын Валютын Сангийн зургаа дахь шатны үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтэд онцолжээ. Мөн зээлийн өндөр өсөлтийг хязгаарлах макро зохистой бодлогын арга хэмжээ авах хэрэгтэй гэж зөвлөсөн байна.

Азийн Хөгжлийн банк мөн урсгал дансны алдагдал өсөх төлөвтэй байгаа нь ирэх онд Монгол Улсын эдийн засгийн сорилт болно гэж үзжээ. Энэ оны эхний сарын байдлаар төлбөрийн тэнцлийн алдагдал өссөөр 500 орчим сая ам.долларт хүрээд байна.

Монголбанк 2019 оноос хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах макро зохистой бодлогын гурван шийдвэрээ хэрэгжүүлнэ. Тухайлбал, иргэдийн өр орлогын харьцаанд 70 хувийн хязгаар тогтоох, валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувь болгож өсгөх, ипотекийн бус хэрэглээний зээлийн хугацаанд 30 сарын хязгаар тавих зэрэг шийдвэрүүд хэрэгжихээр хүлээгдэж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.